



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/431

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/59 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/59 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд малчдыг мэдээллээр хангах зорилготой 2023 оны 05 дугаар сарын 17-ний өдөр Мөрөн суманд зохион байгуулсан “Хоймор нутгийн малчид” зөвлөлдөх уулзалтын үйл ажиллагааны зардлын үлдэгдэл санхүүжилт 3,370,000 (Гурван сая, гурван зуун далан мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 3,370,000 (Гурван сая гурван зуун далан мянган) төгрөгийг Засаг дарга дансны мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П. ЛХАГВАЖАВ

